



## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Аудитын нэр, код.....	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилт.....	4
Аудитын хамрах хүрээ.....	4
Үндсэн мэдээлэл.....	4
Эрсдэлийн үнэлгээ.....	5
Аудитын арга зүй.....	5
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	6
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	6
Аудитын хугацаа.....	6
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл.....	6
Аудитын тайлан.....	7-11
Дүгнэлт.....	12
Зөвлөмж.....	13
Хавсралтууд	



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/51

Улиастай

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж олон нийтэд мэдээлэх аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж олон нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу аудитын дүнг нийтэд мэдээлэхийг аудитын баг (аудитор Б.Мөнхнасан)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг шинжээч (Ч.Ундармаа)-д, тайланг нээлттэй аудит сайтад байршуулахыг аудитор (Г.Нармандах)-д аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (аудитор Б.Мөнхнасан)-д тус тус үүрэг болгосугай.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т даалгасугай.



Д.БАТ-УНДРАА

013010105

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 4 дугаар  
сарын 17-ны өдрийн 151 дугаар тушаалын  
Т хавсралт



Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намд  
болон нэр дэвшигчдэд 1-сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт

№	Нэр	Хандивын дүн, төгрөг
1	Б.Дэлгэрмаа	1,000,000.0
2	Т.Содномцог	2,000,000.0
3	н.Баянзул	2,000,000.0
4	Д.Даваадолгор	1,300,000.0
5	М.Бадамаанямбуу	1,000,000.0
6	М.Дамдинбазар	1,000,000.0
7	О.Өлзийт	2,000,000.0
8	Г.Мөнх-Амгалан	2,000,000.0
9	Ж.Норолхоожав	1,000,000.0
10	н.Гомборагчаа	1,000,000.0
11	Ц.Одончимэг	2,000,000.0
12	Д.Цангиа	1,000,000.0
13	С.Цэндсүрэн	1,800,000.0
14	Д.Цэнд-Аюуш	2,000,000.0
15	М.Рэнчинжүгдэр	2,000,000.0
16	Д.Цэнд-Аюуш	2,000,000.0
17	Г.Цогзолмаа	1,800,000.0
18	Г.Мөнх-Амгалан	1,000,000.0
19	Б.Адарбалгун	1,000,000.0
20	Р.Төгсбат	2,000,000.0
21	Н.Давааням	2,000,000.0
22	н.Мижиддорж	2,000,000.0
23	Э.Болдбаатар	1,000,000.0
24	Б.Цогт	1,000,000.0
25	П.Тунгалагбаяр	1,000,000.0
26	Л.Цаваандорж	1,000,000.0
27	М.Золжаргал	1,000,000.0
28	Мөнхжаргал	1,000,000.0
29	Ц.Лхагвасүрэн	1,000,000.0
30	Ц.Дагвадорж	1,000,000.0
31	н.Алтансүх	1,000,000.0
32	Ц.Гомбодорж	1,000,000.0
33	Д.Тогосбаяр	1,000,000.0
34	З.Батбаатар	2,000,000.0
<b>Нийт</b>		<b>47,900,000.0</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчилсон үг	Товчилсон үгийн тайлбар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам

### Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Нийт нэр дэвшигчдийн тоо	7
Хүснэгт 2	Аймгийн ИТХ-д нэр дэвшигчдийн тоо	8
Хүснэгт 3	Сумын ИТХ-д нэр дэвшигчдийн тоо	8
Хүснэгт 4	Намуудын дансны дугаар	8
Хүснэгт 5	Тайлан ирүүлээгүй нэр дэвшигчдийн тоо	10

### Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Орлогын судалгаа тоо	9

**1. Аудитын нэр:**

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайланг хянаж, үр дүнг олон нийтэд мэдээлэх.

**2. Аудитын код: /ЗАА-2024/12-ШТА-НА**

**3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57 дугаар зүйлд заасан зардлын зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийнэ.

**4. Аудитын зорилт:**

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх.

**5. Хамрах хүрээ:**

Аймаг болон сумдын Монгол ардын нам, Ардчилсан нам, Хүн нам болон бие даан нэр дэвшигчид.

**6. Үндсэн мэдээлэл:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нийт 440 мандаттай, 115 хэсгийн хороо, 146 даамал, мэдээллийн технологийн 5 ажилтан, цагдаа, эрүүл мэнд халдвар хамгаалалтын бусад ажилтнуудыг ажиллуулахаар зохион байгуулсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн тоо

№	Нам эвслийн нэр	Намын тоо	Суманд дэвшигчдийн тоо	Аймагт нэр дэвшигчдийн тоо
1	Монгол ардын нам	1	440	35
2	Ардчилсан нам	1	440	35
3	Хүн нам	1	0	2
4	Бие даан нэр дэвшигч		8	3
Нийт			888	75

## 7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад урьдчилсан судалгааг хийж нөхцөл байдлыг тодорхойлж “Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” аудитын эрсдэлийн үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

## 8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-нийцлийн аудит MNS 6817-7:2020, Нийцлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт өглөө.

## 9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрхийн акт

## 10. Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл

Аудитыг 2024 оны 11 сарын 20-ноос 2024 оны 12 сарын 15-ны хооронд гүйцэтгэж, дүгнэлт гаргалаа.

## 11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-ундраа хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Аудитор Б.Мөнхнасан, Л.Гансүлд нар аудитыг хийж гүйцэтгэлээ.

## **Бүлэг-1. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн хандивын данс нээлгээгүй 16 нэр дэвшигч байна.**

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Монгол ардын нам, Ардчилсан нам, Хүн нам сонгуулийн зардлын дансаа хуульд заасны дагуу нээж бүртгүүлсэн байна.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 3 намын 952, бие даагч 11 нэр дэвшигч нэр дэвшсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд

/Хүснэгт 1/

№	Намын нэр	Намын тоо	Нэр дэвшигчдийн тоо
1	Монгол ардын нам	1	440+35
2	Ардчилсан нам	1	440+35
3	Хүн нам	1	2
4	Бие даагч		8+3
Нийт			963

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-д “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ”, 50.3-т “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу

сонгуулийн зардлын дансаа нээж дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 947 нэр дэвшигч, данс нээлгээгүй 16 нэр дэвшигч байна.

Үүнээс: МАН-аас Сонгино сумд-3, Шилүүстэй сумд-2, АН-аас Баянтэс сумд-3, Их-Уул сумд-1, Отгон сумд-2, Шилүүстэй сумд-4, бие даагч 1 байна.

Энэ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 50.3-р зүйлийг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийн тоо

/Хүснэгт 2/

№	Намын нэр	Намын тоо	Нэр дэвшигчдийн тоо
1	Монгол ардын нам	1	35
2	Ардчилсан нам	1	35
3	Хүн нам	1	2
4	Бие даагч		3
Нийт			75

Сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийн тоо

/Хүснэгт 3/

№	Намын нэр	Намын тоо	Нэр дэвшигчдийн тоо
1	Монгол ардын нам	1	440
2	Ардчилсан нам	1	440
3	Хүн нам	1	0
4	Бие даагч		8
Нийт			888


**Бүлэг-2 Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намууд зардлын тайландаа дүгнэлт гаргуулсан боловч 69 нэр дэвшигч зардлын дансны тайлан ирүүлээгүй, аудитын дүгнэлт гаргуулаагүй байна.**

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Монгол Ардын намын зардлын тайланд гүйлгээ гараагүй, Хүн нам хандивын данс нээлгээгүй, Ардчилсан намын зардлын дансанд орлого зарлагын гүйлгээ хийгдэж аудитаар дүгнэлт гаргуулсан байна.

№	Намын нэр	Намын тоо	Данс нээсэн эсэх	Дансны дугаар	Гүйлгээ гарсан эсэх
1	Монгол ардын нам	1	Тийм	170001886573	Үгүй
2	Ардчилсан нам	1	Тийм	5495337910	Тийм
3	Хүн нам	1	Үгүй	Данс нээлгээгүй	Үгүй

**Орлого:** Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд тайлангаар нийт 182,708.9 мянган төгрөгийн хандивын орлого бүрдсэнээс МАН-д 97,101.9 мянган төгрөгийн, АН-д 75,779.5 мянган төгрөгийн, ХҮН-д 1,165.0 мянган төгрөгийн бие даагч нарт 8662,4 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Зураг-1



Аудитын хуулийн этгээдүүдийн дүгнэлтээс харахад нам болон хуулийн этгээд, иргэнээс мөнгөн бус хандив аваагүй байна.

**Зарлага:** Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 181,595,5 мянган төгрөгийг зарцуулснаас тээвэр шатахууны, ухуулагчийн, түрээсийн байрны, хоолны, унааны болон бусад зардалд зарцуулжээ.

Орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигч нарт иргэний нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэр бичээгүй 61 иргэнээс 30,195.7 мянган төгрөгийн хандив шилжүүлсэн зөрчил байгаагаас 43 нэр дэвшигчийн 13,323.2 мянган төгрөгийн хандивыг буцааж, 18 нэр дэвшигчийн 4,875.5 мянган төгрөгийн хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаагаагүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-д "Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх

мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчжээ.

Хуулиар хүлээн зөвшөөрөөгүй хандив авч зарцуулсан жагсаалтыг Аймгийн Засаг даргад хүргүүлэн Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авч биелэлтийг тайлагнаж ажиллахыг хариуцуулав.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс зардлын дансны тайлан ирүүлээгүй 69 нэр дэвшигч байна. Энэ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

Хүснэгт-5

№	Сумын нэр	Намын нэр	Тоо	Дүгнэлт гаргуулаагүй
1	Баянтэс сум	АН	2	+
2	Нөмрөг сум	АН	4	+
4	Цэцэн-Уул сум	АН	3	+
5	Улиастай сум	АН	6	+
6	Отгон сум	АН	3	+
7	Шилүүстэй сум	АН	3	+
8	Асгат	МАН	1	+
9	Сантмаргаз сум	МАН	15	+
10	Нөмрөг сум	МАН	1	+
11	Түдэвтэй сум	МАН	3	+
12	Тосонцэнгэл сум	МАН	1	+
13	Тэс сум	МАН	12	+
14	Ургамал сум	МАН	1	+
15	Отгон сум	МАН	10	+
16	Улиастай сум	ХҮН	1	+
17	Баянтэс сум	Бие даагч	1	+
18	Нөмрөг сум	Бие даагч	1	+
19	Тэлмэн сум	Бие даагч	1	+

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/23 тоот тушаалаар Аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 1800,0 мянган төгрөгөөс 23,700 мянган төгрөгийн хооронд тогтоосон

бөгөөд Завхан аймгийн Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигч нар зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аудитаар нийт 30,195.7 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгуулах 2 зөвлөмж хүргүүлээ.

## ДҮГНЭЛТ

---

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.**

1. Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон зарим нэр дэвшигчдийн сонгуулийн тухай хууль, журмын мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалан санхүүжилтийн эх үүсвэр нь хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна.
2. Хандив өгч байгаа иргэд сонгуулийн тухай хууль журмын мэдлэг дутмаг, мэдээллээр бүрэн хангагдаагүй байгаагаас шалтгаалан овог нэр, регистрийн дугаар, санхүүжилтийн эх үүсвэрийг бичдэггүй дутагдал байна.
3. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй, хуулиар хүлээн зөвшөөрөөгүй хандивыг буцаагаагүй зориулалт бусаар зарцуулсан байна.

## **ЗӨВЛӨМЖ**

---

**Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.**

Аймгийн Засаг дарга болон Татварын газарт:

1. Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигч нарт иргэний нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэр бичээгүй 92 иргэнээс 30,195.5 мянган төгрөгийн хандив шилжүүлсэн зөрчил байгаагаас 43 иргэний 13,323.1 мянган төгрөгийн хандивыг буцаасан, 18 иргэний 4,875.5 мянган төгрөгийн хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаагаагүй зарцуулсан байгаа тул Аймаг Нийслэл Сум Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасны дагуу арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу ирүүлэх;
2. Сонгуульд оролцсон нам эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, аудит хийхэд сонгуулийн зардлын дансны тайлан ирүүлээгүй дүгнэлт гаргуулаагүй 69 нэр дэвшигч нарт Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасны дагуу арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу ирүүлэх;
3. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 16-ны дотор хариу ирүүлэх.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

**Д.БАТ-УНДРАА**

---